



МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН ХИ АНГИЙН СУРАГЧДЫН II ДАВААНЫ СЭДЭВ

Оноо 40. Хугацаа 120 минут

Санамж:

1. Даалгавруудыг эх сэдэв дээр биш, тусгай цаасан дээр гүйцэтгэнэ.
2. Ажил тус бүрийн дугаар, дэд дугаарыг тодорхой бичнэ.
3. Зарим даалгаврыг эх сэдвээс нь хуулж бичээд гүйцэтгээрэй.

Даалгавар гүйцэтгэхэд ашиглах эх

Б.Явуухулан

Миний араншин

Хөхөөн дууны ногоохон зунаар
Хөвч хангайнхаа зусланд байхдаа
Хавтгайн чөмөг царцам өвлөө
Харахсан гэж хүсдэг шигээ би,
Цэцэгт хангайдаа давхиж явахдаа
Цэнхэрхэн говьдоо очихсон гэж яарах юм.

Буурын шүдний хангинах өвлөөр
Бударганат говийнхоо өвөлжөөнд байхдаа
Хандгай аяндаа хөлрөм зунаа
Харахсан гэж хүсдэг шигээ би,
Алтан говьдоо давхиж явахдаа
Аглагхан хангайдаа очихсон гэж яарах юм.

Цэнхэр яргуй нүдлэх хавраар
Цэлгэрхэн талынхаа хаваржаанд байхдаа
Өнчин янзага өөхлөх намраа
Үзэхсэн гэж хүсдэг шигээ би,
Цайдам талдаа давхиж явахдаа
Цастайхан ууландаа очихсон гэж яарах юм.

Халиун бугын урамдах намраар
Хан уулынхаа намаржаанд байхдаа
Ууган төл цангинах хавраа
Үзэхсэн гэж хүсдэг шигээ би,
Үүл шүргэсэн ууланд явахдаа
Өргөнхөн талдаа очихсон гэж яарах юм.

Энэ бүхэн ...
Эцэг эхээс ...
Өвөл, зун, ...
Уул, тал, ...
Тийм нутагт ...
Тэгээд ч би ...

Нэгдүгээр ажил. Эх, өгүүлбэрийн задлал (15 оноо)

1.1. Энэ шүлэг 5 бадагтай. Танд төсгөлийн бадгийн 6 шадын эхний 2 үгийг өгөв. Зохиолч ингэж л бичсэн байх гэж бодоод гүйцээнэ үү. (3 оноо)

Энэ бүхэн ...

Эцэг эхээс ...

Өвөл, зун, ...

Уул, тал, ...

Тийм нутагт ...

Тэгээд ч би ...

1.2. Шүлгийн нэрийг юунд тулгуурлан өгсөн бэ? Яагаад гэдгийг оновчтой тайлбарла. (1 оноо)

1.3. Шүлгийн гол санааг товч тодорхойлно уу. (2 оноо)

1.4. Дээрх шүлгийн бадаг бүрийн нэгдүгээр мөрүүдэд улирлын ямар онцлогийг дүрсэлсэн бэ? Нэг л өгүүлбэрээр тодорхойлно. Гуравдугаар мөрүүдтэй харьцуулж ажиглах. (2 оноо)

1.5. Шүлгийн бадаг тус бүрийн тав, зургадугаар мөрүүдийн эхний (цэцэгт, цэнхэрхэн гэх мэт...) тодотголууд дүрслэх ямар ур маяг вэ? (1 оноо)

1.6. Шүлгийн эхний 4 бадгийн (1 ба 2, 3 ба 4) харшуулах (эсрэгцүүлэх) ур маягийг цаг, орны талаас нь тайлбарла. (3 оноо)

1.7. Дараах өгүүлбэрийг өгүүлбэрийн гишүүдээр зурж бүтцийг тодорхойл. (3 оноо)

Буурын шүдний хангинах өвлөөр

Бударганат говийнхоо өвөлжөөнд байхдаа

Хандгай аяндаа хөлрөм зунаа

Харах сан гэж хүсдэг, би

Хоёрдугаар ажил. Үг бүтээврийн задлал (10 оноо)

2.1. Дараах үгсийн утгыг тайлбарла. (3 оноо)

араншин-

хөвч-

буур-

аглагхан-

ууган-

бударгана-

2.2. Дээрх шүлэгт орсон “ногоохон, цэнхэрхэн, аглагхан, цэлгэрхэн, өргөнхөн” гэх мэт үгийн бүтцэд орсон **-хан(-хэн, -хон, -хөн)**, “царцам, хөлрөм” зэрэг үгийн бүтцэд орсон **-м** зэрэг нөхцөлүүд ямар баймж утгатай вэ? (2 оноо)

2.3. “Харахсан, үзэхсэн, очихсон” зэрэг үгийн бүтэц дэх **сан (сэн)** гэдэг ямар утга, үүрэгтэй вэ? Зөв бичгийн дүрмийн үүднээс нийлүүлж бичих нь зөв үү? (1 оноо)

2.4. “Цангинах” гэдэг үгийг бүтээврээр задалж, бүтээвэр тус бүрийг нэрлэ. (2 оноо)

2.5. Шүлгийн нэгдүгээр бадагт нэрлэх, харьяалахын тийн ялгалд байгаа үгсийг бүлэглэж бичнэ үү. (2 оноо)

Гуравдугаар ажил. Зохион бичлэг (5 оноо)

“Яргуй нүдлэх улирал ба би” сэдвээр 90-100 орчим үгтэй зохиомж бичээрэй.

Дөрөвдүгээр ажил. Монгол бичиг (10 оноо)

“Миний араншин” шүлгийн эхний хоёр (1 ба 2) бадгийг монгол бичгээр хөрвүүлж бичээрэй.